

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ САЙЖРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЗӨВЛӨМЖ

ОРШИЛ

Монголын хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хороо, Нээлттэй нийгэм форум ТББ хамтран Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийг 2023 оны 10 сарын 29-ны өдөр зохион байгууллаа. Уг хэлэлцүүлэгт УУХҮЯ-ны төлөөлөл, Захиргааны эрх зүйн хорооны гишүүн хуульчид, хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм болон уул уурхайн компаниудын төлөөлөл 80 орчим хүн оролцож, хуулийн төсөлтэй холбоотой санал шүүмж өрнүүлснийг ийнхүү нэгтгэн хүргэж байна.

Энэхүү санал шүүмжийг УУХҮЯ-ны боловсруулж буй Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хувилбарт үндэслэн боловсруулсан болно.

НЭГ. ХУУЛИЙН ТӨСӨЛ НЬ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН ХУУЛИЙН ТӨСЛИЙН БАТЛАГДСАН ҮЗЭЛД БАРИМТЛАЛДАА НИЙЦЭХГҮЙ БАЙНА.

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын (цаашид хуулийн төсөл гэх) Үзэл баримтлалд Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт өөрчлөлт болон уг нэмэлт өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх тухай УИХ-ын тогтоол, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх явдлыг уг хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл хэмээн тодорхойлжээ.

Гэтэл хуулийн төсөл нь дээрх хууль зүйн үндэслэл буюу 1) Үндсэн хуулиар баталгаажсан өнөө болон ирээдүй үеийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, мэдэх эрхийг хангах зарчим, 2) УИХ-ын 2020 оны 02 дугаар тогтоолд онцлон тэмдэглэсэн “...байгалийн баялаг ашиглах шийдвэр гаргах зарчим, журмыг боловсронгуй болгох, онцгой ач холбогдол бүхий зарим асуудлаар иргэдтэй зөвлөлдөх, тэдний саналыг авч тусгах механизмыг тодорхой болгох, уялдаа холбоог хангах, байгалийн тэнцлийг хангах, нөхөн сэргээхтэй холбоотой талуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгох” чиглэл, 3) Алсын хараа-2050, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх зорилтуудыг хангаж чадахааргүй байна. Иймд хуулийн төслийг Үндсэн хуулийн үзэл санаа, хуулийн төслийн батлагдсан Үзэл баримтлалд нийцүүлээгүй нөхцөлд түүнийг батлан гаргах боломжгүй гэж үзэж байна.

Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулах, байгалийн тэнцлийг хангах шаардлагад бүрэн нийцэхгүй талаар:

- Ой болон усан сан бүхий газар, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн дэглэмийг үл харгалзан хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахаар тусгасан;
- Уул уурхайн үйл ажиллагааг хориглох, хязгаарлах газрыг зөвхөн Ашигт малтмалын тухай хуулиар тогтоож, бусад хууль тогтоомжтой зөрчилдвөл энэ хуулийг баримтлахаар заасан нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Газрын тухай, Усны тухай, Гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагааг хориглох тухай, Амьтны тухай хууль, Байгалийн ургамлын тухай хууль зэрэг хүчин төгөлдөр үйлчилж байгаа олон хуулийн үйлчлэлийг дордуулах эрсдэлтэй;
- Хуулийн төсөлд уул уурхайн үйл ажиллагааг хориглох газрыг тодорхойлсон байх боловч ийнхүү хориглосон газарт стратегийн болон чухал ашигт малтмалын үйл ажиллагаа явуулж болохоор заасан;
- Хайгуул, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулахгүй байхаар заасан нь уул уурхайн салбарт Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн үйлчлэлийг хязгаарлан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны үүрэг, хариуцлагыг сулруулах үр дагавартай байна. Тодруулбал:
 - o Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулна гэсэн нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулиар тодорхойлсон байгаль орчны менежментийн төлөвлөгөө бус учраас түүнийг батлах, хэрэгжилтийг хянах үүрэг төрийн аль нэг байгууллагад үүсэхгүй;
 - o Ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан гаргах үүргийг хасаж, хаалтын төлөвлөгөөгөөр орлуулжээ. Хаалтын төлөвлөгөөг онцгой нөхцөл байдал үүсээгүй эсхүл тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрөө санаачилга гаргаагүй тохиолдолд 5 жилд нэг удаа тодотгох, жил бүрийн нөхөн сэргээлтийн явцыг байгаль орчны байгууллагад тайлагнах үүрэг хүлээхээргүй байгаа нь уул уурхайн үйл ажиллагаа бүхэлдээ байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн байгууллагын хяналтаас гарах эрсдэл үүсгэж байна.
- Ийнхүү байгаль орчны асуудал төрийн захиргааны байгууллагын хяналтыг сулруулаад зогсохгүй байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайланг батлах сум, дүүргийн Засаг даргын эрх хэмжээг хассан заалт хуулийн төсөлд туссан;
- Иргэдийн байгаль орчны болон өмчлөх эрх зөрчигдсөн тохиолдолд авах арга хэмжээг орхигдуулсан. Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, нөхөн төлбөр олгох журам, аргачлал тодорхойгүй байгаагаас практикт харилцан адилгүй жишиг тогтож, эцэстээ иргэд хохирч

үлдэх явдал түгээмэл гардаг. Гэтэл шинэчилсэн найруулгын төсөлд уул уурхайн төсөлд нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх, нөхөн төлбөр, нүүлгэн шилжүүлэлтэд баримтлах журам, аргачлалын талаар ямар нэг зохицуулалт тусаагүй хэвээр байна;

- Уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн нэг хэсэг болох тээврийн үйл ажиллагаанд тавих байгаль орчны шаардлагыг хуульчлаагүй.

Иргэдийн мэдэх эрхийг хангах, УИХ-ын тогтоолд онцлон заасан иргэдийн санал авах, зөвшилцөх механизмыг бий болгох шаардлага болон урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгасан ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх зорилтод нийцээгүй талаар:

- Монгол Улс 2006 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ыг хэрэгжүүлэх суурь зохицуулалтыг орхигдуулсан. Эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг хангах асуудлыг бие даасан хуулиар баталгаажуулах санал санаачилга өрнөөд нэлээд олон жил өнгөрсөн боловч энэ асуудалд салбарын бодлого хариуцсан яам ач холбогдол өгөхгүй байгаагаас зогсонги байдалд ороод байна. Иймд ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой суурь зохицуулалтыг Ашигт малтмалын тухай хуулиар бий болгох нь зүйтэй. Гэтэл хуулийн төсөлд салбарын удирдлагын тогтолцоог тодорхойлсон байх боловч ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, ажлын албыг орхигдуулсан, эрдэс баялгийн мэдээллийн сангийн зохицуулалтад ОУИТБС-ын мэдээллийн санг хамруулаагүй байна;
- Тэрчлэн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх зохицуулалт байхгүй буюу тусгай зөвшөөрөл олгох үйл явц, сонгон шалгаруулалтын комисс болон эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн томилгоо, шийдвэр, үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад чиглэсэн ямар нэг заалт байхгүй байна;
- Тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг тогтоох, хайгуул, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох зэрэг үйл явцад орон нутаг, иргэдийн оролцоог бүрэн орхигдуулсан буюу хуулийн төслийн 5 дугаар зүйлд заасан талуудын тэгш оролцооны зарчмыг хангах механизм хуулийн төсөлд тусгагдаагүй байна;
- Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицол тогтооход нутгийн захиргаа, ИТХ-аас санал авах зохицуулалтыг хассан нь иргэд, орон нутгийн оролцоог хангахтай холбоотой өнөөгийн эрх зүйн орчныг дордуулахаар байна.

Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн найруулах практик шаардлага буюу хууль тогтоомжийн зөрчил, хийдлийг арилгах хэрэгцээ шаардлагад нийцээгүй талаар:

- Хуулийн төслийн Үзэл баримтлалд байгалийн баялаг ашиглах харилцаанд үүсэж

буй хууль тогтоомжийн зөрчил, хийдлийг арилгах нь энэ удаагийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад баримтлах практик шаардлага хэмээн тодорхойлжээ. Гэтэл хуулийн төсөлд дээр дурдсанчлан хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудтай агуулгын хувьд зөрчилтэй олон заалт туссан байна. Энэ нь зөвхөн хуулийн төслийн Үзэл баримтлалд нийцэхгүй төдийгүй аливаа хуулийн төсөл агуулгын хувьд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хуультай уялдсан байх тухай Хууль тогтоомжийн тухай хуулиар тогтоосон шаардлагад нийцэхгүй юм.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

- Хуулийн төслийн үзэл баримтлал, холбогдох тооцоо, судалгаа, дагалдах хуулийн төслийг ил тод болгож, оролцогч талуудад хуулийн төслийг бүх талаас нь бүрэн дүүрэн шинжлэн санал зөвлөмж өгөх боломж бүрдүүлэх;
- Эрх ашиг нь хөндөгдөх тал буюу уул уурхай бүхий орон нутгийн иргэдээр хуулийн төслийг хэлэлцүүлэх. Ингэхдээ хуулийн төслийг бүрдүүлбэрийн хамт урьдчилан танилцуулах замаар санал, шүүмжээ бэлтгэх боломж олгох ба санал шүүмжийг хэрхэн тусгасныг саналын товъёгт тусгаж нийтлэх нь зүйтэй.

ГУРАВ. ТУСГАЙ САНАЛ ШҮҮМЖ

Хууль тогтоомжийн хооронд зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн санал

- Хуулийн төслийн зорилгыг Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн үзэл санаанд нийцүүлж, хамгаалахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгах шаардлагын үүднээс дахин томъёолох;
- Хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-д заасан шаардлагад нийцүүлж, бусад хууль тогтоомжтой зөрчилдсөн заалтуудыг өөрчлөн сайжруулах;
- Хууль тогтоомжийн системчлэлийн онолд харшилж байх тул хуулийн төслийн 75.3 дахь заалтыг хасах;
- Захиргааны ерөнхий хуулиар тогтоосон бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд тэдгээрт урьдчилан мэдэгдэх оролцоог нь хангах зарчмыг баримталж, талбайн солбицол тогтоох болон тусгай зөвшөөрөл олгох зэрэг захиргааны шийдвэр гаргах үйл явцыг Захиргааны ерөнхий хуулийн сонсох ажиллагаа, төлөвлөлтийн эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэх;

- Хуулийн төслийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь заалтыг “Ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай, үйлдвэр байгуулахтай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив тусламж өгөх асуудлаар сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулж, аймаг, нийслэлийн Засаг дарга баталгаажуулна” гэж өөрчлөх. Учир нь уг гэрээ нь захиргааны эрх зүйн гэрээ атал хамтран ажиллах гэрээ гэж нэрлэх нь иргэний эрх зүйн гэрээтэй андуурагдан зохицуулалтын буруу үр дагавар үүсгэх эрсдэлтэй;
- Хуулийн төслийн 48 дугаар зүйлд “сум, дүүргийн Засаг дарга нь энэ зүйлд заасан гэрээ байгуулахад Захиргааны ерөнхий хуульд заасан сонсох ажиллагаа явуулна” гэсэн заалт нэмж, ийнхүү гэрээ байгуулах үүргийн хэрэгжилтийг хангах хариуцлагын зохицуулалтыг бий болгох;
- Хуулийн төслийн 48 дугаар зүйлд “Энэ зүйлийн 48.2-т заасан гэрээний үндсэн нөхцөлийг ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл хүсэх өргөдөл гаргахаас өмнө орон нутагтай харилцан тохиролцсон байх бөгөөд тусгай зөвшөөрөл авсны дараа баталгаажуулна” гэсэн заалт нэмэх;
- Хуулийн төслийн 49 дүгээр 49.1 дэх хэсэгт “байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны” гэсний дараа “орон нутагтай байгуулсан гэрээ, түүний хэрэгжилтийн мэдээлэл” гэж нэмэх;
- Хуулийн төслийн 49 дүгээр зүйлийн 49.3-т заасан “...сурталчлах”, “ашигт малтмалын хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаанд саад учруулахгүй байх нөхцөлийг хангах үүрэгтэй” гэснийг хасах;
- Хуулийн төслийн 10 дугаар зүйлд нийт 38 төрлийн багц дүрэм батлахаар тусгасан нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-т заасан тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх, 29.1.18-д заасан нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх шаардлагад нийцэхгүй байна. Иймд орон нутгийн иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөж болзошгүй бөгөөд авлига, ашиг сонирхлын эрсдэл бүхий дараах үйл явцыг журмаар бус хуулиар зохицуулах нь зохистой. Үүнд:
 - o Хайгуул, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр болон сонгон шалгаруулалтаар олгохтой холбоотой төрийн захиргааны байгууллага, сонгон шалгаруулалтын комисс, түүний дарга, нарийн бичгийн дарга, гишүүний эрх үүрэг, хариуцлага, шийдвэр гаргах болон маргаан шийдвэрлэх үйл явц, түүний ил тод байдал;
 - o Сонгон шалгаруулалтын комиссын гишүүнд тавих шаардлага, томилгооны үйл явц, түүний ил тод байдал;
 - o Хайгуул, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх баримт бичиг, өргөдөл гаргагчид тавих техник технологи, ажиллах хүчний шаардлага;

- o Технологийн аудит, маркшэйдрийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох үйл явц, түүнтэй холбоотой төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг, дээрх үйл ажиллагааг эрхлэх этгээдэд тавих үндсэн шаардлага, үүрэг, хариуцлага, хяналт;
- o Салбарын мэргэшсэн мэргэжилтний эрх олгох үйл явц, түүнтэй холбоотой төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг, дээрх үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавих үндсэн шаардлага, үүрэг, хариуцлага, хяналт;
- o Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл, гишүүний эрх, үүрэг, хариуцлага, гишүүнд тавих мэргэжлийн болон ёс зүйн шаардлага, сонгон шалгаруулалтын үйл явц, томилгооны хугацаа, чөлөөлөх үндэслэл, шийдвэр гаргах үйл явц, зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавих журам;
- o Геологи, уул уурхайн асуудал хариуцсан орон нутаг дахь нэгжийн чиг үүрэг, үйл ажиллагааны ил тод байдал;
- o Үүсмэл орд ашиглах зөвшөөрөл олгохтой холбоотой төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг, шийдвэр гаргах үйл явц, түүний ил тод байдал, үүсмэл орд ашиглах этгээдэд тавих шаардлага, хяналт;
- o Тусгай зөвшөөрөл шилжүүлэх зөвшөөрөл олгох үйл явц, түүний ил тод байдал, төрийн захиргааны байгууллагын эрх үүрэг, тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авч байгаа этгээдэд тавих шаардлага;
- o Тусгай зөвшөөрлийн талбайн хилийн маргаан шийдвэрлэх үйл явц, хугацаа, ил тод байдал, төрийн захиргааны байгууллага, бусад оролцогч талын эрх, үүрэг;
- o Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн жилийн нөхөн сэргээлтийн зардлыг байршуулах, хүлээн авах, буцаан олгох, зарцуулах журам, түүнтэй холбоотой төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг;
- o Хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааны улмаас бусдын эзэмшил, ашиглалт, өмчлөлийн хөрөнгөд учруулсан гэм хорыг арилгах болон нүүлгэн шилжүүлэх нөхөн төлбөр олгох үйл явцыг хуульчилж, нөхөн төлбөрийн хэмжээ тооцох аргачлалыг Засгийн газар батлахаар тусгах;
- o Ордын нөөцийн ангиллыг хуулиар тогтоож, харин тухайн ордын хувьд ангиллыг тогтоох заавар, нөөцийн үнэлгээний аргачлалыг журмаар тодорхойлох.

Ил тод байдлыг хангах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэхэд чиглэсэн санал

- Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.4-т хайгуулын тусгай зөвшөөрлийг дуудлага худалдаагаар явуулахаар заасан байх боловч дуудлага худалдааг зохион

- байгуулахтай холбоотой үйл явц, төрийн захиргааны байгууллага, оролцогчдын эрх үүргийг зохицуулаагүй байгааг залруулах;
- Хуулийн төслийн 67 дугаар зүйлд эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх дараах заалтуудыг нэмж тусгах:
 - o Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл, дэд зөвлөлийн гишүүн, энэ хуулийн төслийн 67.6-д заасны дагуу томилогдсон шинжээч, зөвлөх, мэргэшсэн мэргэжилтний нэр, мэргэжил, туршлагыг илэрхийлэх мэдээлэл, тэдгээрийн хамаарал бүхий этгээд, эрдэс баялгийн салбартай холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг нэгдмэл сонирхолтой хуулийн этгээдийн мэдээлэл;
 - o Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл, дэд зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага, сонгон шалгаруулалтын үйл явц, шийдвэр, томилгооны хугацаа;
 - o Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл, дэд зөвлөлийн шийдвэр дэх хуулиар хамгаалагдсан нууцад хамаарахаас бусад мэдээлэл;
 - o Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн гишүүний эрх, үүрэг;
 - o Тухайн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, ашиглалт, баяжуулалтын техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төслийг хэлэлцүүлж буй хуулийн этгээд болон дүгнэлт гаргасан мэргэшсэн шинжээч, эрх олгогдсон зөвлөх, мэргэшсэн мэргэжилтэнтэй төрөл, садангийн холбоотой, нэгдмэл сонирхолтой эсхүл ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон бол шийдвэр гаргахад оролцохоос татгалзах үүргийг тус тус хуульчлах.
 - Хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын комиссын гишүүний нэр, мэргэжил, туршлагыг илэрхийлэх мэдээлэл, тэдгээрийн хамаарал бүхий этгээд, эрдэс баялгийн салбартай холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг нэгдмэл сонирхолтой хуулийн этгээдийн мэдээлэл;
 - Хуулийн төсөлд улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн орд, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахад орд ашиглах гэрээ байгуулахаар заасан атал гэрээний агуулга, гэрээ байгуулах үйл явц, төрийн байгууллагын эрх, үүргийг хуульчлаагүй үлдээснийг залруулах;
 - Орд ашиглах гэрээний ил тод байдлыг хангах зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж тусгах;
 - Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хэрэгжилтийг баталгаажуулах дараах заалтыг хуулийн төсөлд нэмж тусгах:
 - o Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.2 болон 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт “үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх” гэсэн заалт нэмэх;
 - o Хуулийн төсөлд “тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд олборлосон, борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт

төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээ, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны төсөв, зарцуулалт, орон нутагтай байгуулсан гэрээ, түүний хэрэгжилтийн мэдээллийг дараа оны 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ” гэсэн заалт нэмж тусгах;

- o Хуулийн төслийн Арван тавдугаар бүлэгт Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын Үндэсний зөвлөл, түүний ажлын албаны эрх, үүргийг нэмж тусгах;
- o Арван зургаадугаар бүлэгт заасан Геологи, уул уурхайн салбарын мэдээллийн сангийн зохицуулалтад Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын мэдээллийн сан, түүний бүрдэл, мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбоотой төрийн холбогдох байгууллагын чиг үүргийг тус тус нэмж тусгах.
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн ТУЗ-ийн бүрэн эрхэд халдах эрсдэлтэй байх тул хуулийн төслийн 60 дугаар зүйлийн 60.1.9 болон 60.1.10 дахь заалтыг хасах;
- Эрлийн үйл ажиллагааны сонгон шалгаруулалт зохион байгуулахтай холбоотой үйл явц, ил тод байдал, төрийн захиргааны байгууллагын эрх, үүргийг хуульчлах.

Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад чиглэсэн санал

- Ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааг хориглосон газар нутгийг зөвхөн энэ хуулиар тогтооно гэсэн нь дээр нэр дурдсан байгаль орчны хуулиуд болон Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтыг зөрчиж байх тул хуулийн төслөөс 8 дугаар зүйлийн 8.3-8.6 дахь хэсэг, 59.1.5, 59.1.17 дахь заалтыг хасах;
- Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.4 болон 8.6 дахь хэсэг нь хоорондоо зөрчилдсөн агуулгатай байгаа нь хуулийн төслийн эх бичвэрт тавигдах нийтлэг шаардлага буюу Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-д заасан “зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх” шаардлагыг хангахгүй байгааг залруулах;
- Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.28-д “үйлдвэрлэлийн зориулалттай зам” гэснийг “үйлдвэрлэлийн болон уул уурхайн бүтээгдэхүүний тээврийн зам” гэж өөрчлөх;
- Чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалтыг тусгай хамгаалалттай газар нутаг, хилийн зурвас газар, ойн сан бүхий газар болон усан сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс, зам шугам сүлжээний газарт явуулж болохоор заасан нь байгаль орчинд үлэмж хэмжээний нөлөөлөл үүсгэх үр дагавартай тул чухал ашигт малтмал гэх ойлголтыг хуулиар нарийвчлан тодорхойлж, хуулийн төслийн нэр томъёоны хэсэгт тусгайлан заах;
- Хэд хэдэн аймаг, сумын нутаг дэвсгэрийг хамарсан төсөл хэрэгжүүлэх эсхүл нэг

багийн нутаг дэвсгэрт 2-оос дээш төсөл хэрэгжих тохиолдолд байгаль орчны хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагыг хуульд тусгах;

- Хуулийн төслийн 44 дүгээр зүйлд эрлийн ажлын явцад газрын хэвлий хөндөх тохиолдолд байгаль орчныг хамгаалах зардлыг хаана байршуулахыг тусгах;
- Хуулийн төслийн 18 дугаар зүйлд “хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын үйл ажиллагааг эхлэхээс өмнө байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийнэ” гэсэн заалт нэмэх;
- Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэгт “байгаль орчинд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан” гэсэн заалт нэмэх. Учир нь уурхайн хаалтын төлөвлөгөө нь байгаль орчинд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд суурилан боловсруулагдах учиртай болно;
- Ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэх өргөдөл гаргах буюу хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “ашиглалтын үйл ажиллагааг техник, эдийн засгийн үндэслэлд тодорхойлсон технологийн шаардлагын дагуу гүйцэтгэх мэргэжлийн боловсон хүчин, техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан талаархи мэдээлэл, хайгуулын ажлын явцад байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж ажилласан тухай баримт” гэсэн заалт нэмэх;
- Хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэх өргөдлийг шийдвэрлэхтэй холбоотой төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг хуульчлах. Ингэхдээ зөвхөн өргөдлийн бүрдүүлбэр хангасан эсэхийг шалгах аас гадна тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд, эцсийн өмчлөгч, түүний хамаарал бүхий хуулийн этгээд өмнө нь ашигт малтмалын үйл ажиллагааны явцдаа байгаль орчны үүргийн зөрчил болон авлига, ашиг сонирхлын зөрчил гаргаж байсан эсэхийг төрийн эрх бүхий байгууллага тогтоож байсан эсэхийг шалган тодруулах зохицуулалт нэмж тусгах. Ийнхүү зөрчил гаргаж байсан бол эрсдэл бүхий тусгай зөвшөөрөл гэж үзэн тусгайлсан хяналт тавих журмыг хуульчлах;
- Хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.6-д заасан сонгон шалгаруулалтаар ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан этгээд орд ашиглах бэлтгэл хангах хугацааг ямар үндэслэл, тооцоонд суурилан 3 жил хэмээн тогтоосныг тодорхой болгох;
- Хуулийн төслийн 45 дугаар зүйл болон 49.2-т заасан “байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө” гэснийг “байгаль орчны менежментийн төлөвлөгөө” гэж өөрчлөх;
- Хуулийн төслийн 45 дугаар зүйлийн 45.2-т заасан “гурван жилээр” гэснийг “жил бүр” гэж өөрчлөх;
- Хуулийн төслийн 45 дугаар зүйлийн 45.3 болон 46 дугаар зүйлийн 46.2 дахь заалтыг “сум, дүүргийн байгаль орчны байцаагч болон тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан, байгаль

орчны менежментийн төлөвлөгөө, тайланг олон нийтэд нээлттэй байлгана” гэж өөрчлөх;

- Хуулийн төслийн 45 дугаар зүйлд “хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг батлах, хяналт тавихад Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 болон 9.12 дугаар зүйлийг баримтална” гэсэн заалт нэмэх;
- Хуулийн төслийн 17 дугаар зүйлд байгаль орчны үүрэг зөрчигдсөн тохиолдолд хайгуулын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох зохицуулалт нэмэх;
- Хуулийн төслийн 46 дугаар зүйлийг 5 дугаар зүйлийн 5.1.5-д заасан “уул уурхайн үйл ажиллагааны бүх шатанд байгаль орчныг хамгаалах” зарчимд бүрэн нийцүүлж, “байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ нь олборлолт, баяжуулалтын үйл ажиллагаа, тээвэр, эрчим хүч, холбогдох бусад дэд бүтцийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бүрэн хамарсан байна” гэсэн заалт нэмэх;
- Хуулийн төслийн 46 дугаар зүйлийн 46.6 дахь хэсгийг хасах;
- Хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.5-д тусгай зөвшөөрөл эзэмшигчид харилцан тохиролцсоны үндсэн дээр ашигт малтмалын ордыг нэгдмэл байдлаар ашиглаж болохоор заажээ. Энэ тохиолдолд техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, хаалтын төлөвлөгөөнд тодотгол хийлгэх шаардлагыг хуульчлах.
- Хуулийн төслийн 23 дугаар зүйл нь ашиглалтын тусгай зөвшөөрөл дуусгавар болох, хүчингүй болгох, цуцлах харилцааг зохицуулахаар байх боловч цуцлах үндэслэл, журмыг тогтоогоогүй үлдээжээ. Иймд хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг Захиргааны ерөнхий хуулийн 48 болон 49 дүгээр зүйлд нийцүүлж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, цуцлах үндэслэлийг ялгаатай томъёолох;
- Хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.2.6 дахь хэсгийн тайлбарт “байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ” гэсний дараа “байгаль орчны менежментийн төлөвлөгөө” гэж нэмэх;
- Хуулийн төслийн 23.2.6 болон 29.2.3-д заасан “байгаль орчинд ноцтой хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон” гэснийг “төрийн эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд байгаль орчны үүргийн зөрчлийг арилгаагүй эсхүл байгаль орчинд ноцтой хохирол учруулсан бол” гэж өөрчлөх;
- Хаалтын төлөвлөгөө болон байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний харилцан уялдааг тодорхой болгох. Ингэхдээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нийцүүлэн ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайланг жил бүр гаргах, түүнийгээ байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар хянуулах

үүргийг хуульчлах. Учир нь 5 жилд нэг удаа тодотгон, зөвхөн санхүүжилтийг ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад жил бүр тайлагнах хаалтын төлөвлөгөө нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөг орлох боломжгүй юм;

- Хаалтын төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих үйл явцад байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын оролцоог хуульчлах;
- Ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаанд нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх, бусдын эзэмшил, ашиглалт, өмчлөлийн хөрөнгөд учруулсан гэм хорыг арилгах болон нүүлгэн шилжүүлэх, нөхөн төлбөр олгохтой холбоотой талуудын эрх, үүрэг, үйл явцыг хуульчлах;
- Хуулийн төслийн 31 дүгээр зүйлийн 31.6-д “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэсний дараа “байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран” гэж нэмэх;
- Хуулийн төслийн 64 дүгээр зүйлийн 64.2.1 дэх заалтыг хасах. Учир нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг орон нутгийн иргэдэд танилцуулах нь хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг байх нь зүйтэй;
- Хуулийн төслийн 31 дүгээр зүйлд баяжуулах үйлдвэрийн хаягдлын далан, усан сан бүхий газрын хамгаалалтын бүсээс 2 километрийн дотор, хүн амын унд, ахуйн усан хангамжийн эх үүсвэр, хүн амын суурьшлын бүсэд байгуулахыг хориглох заалт тусгах.

Бусад санал шүүмж

- Хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн хэмжээг тогтооход баримталсан тооцоо судалгааг ил тод болгож, төлбөрийг нэмэгдүүлэн тогтоосноор хүрэх үр дүн болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд, ялангуяа дотоодын аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх нөлөөллийг хэрхэн тооцсоныг харгалзан санал шүүмж өгөх боломжийг бүрдүүлэх;
- Бичил уурхайн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах. Бичил уурхайн талаар зөв ойлголт бий болгож, хууль бусаар ашигт малтмал ашиглах үйл ажиллагаанаас ялгаатайг хүлээн зөвшөөрч холбогдох зохицуулалтыг хуулиар бий болгох нь зохистой. Бичил уурхайг шууд хориглохоос илүүтэй өнөөгийн зохицуулалтын хэрэгжилт, үр нөлөө, үр дагаврыг бүрэн тооцож, холбогдох талуудтай зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэх;
- Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан “дотоодын үйлдвэрлэлийн зориулалттай ашигт малтмал”-гэдэгт юуг ойлгох, хэн, хэрхэн тогтоохыг тодорхой болгох;
- Ашиглалтын үеийн болон гүйцээх хайгуулын ажлын явцын үр дүнг жил бүр тайлагнах шаардлагыг хуульчлах;

- Баяжуулалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг хуулиар тодорхойлж, төлөх журам, төлбөр төлөөгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох зохицуулалт бий болгох. Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.6-д “баяжуулалтын үйл ажиллагааны төлбөрийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан хэмжээгээр төлнө” хэмээн заасан нь Татварын ерөнхий хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиудад нийцэхгүй. Өөрөөр хэлбэл, төлбөр, хураамж нь өөр хоорондоо ялгаатай татварын орлогын бие даасан төрөл бөгөөд улсын тэмдэгтийн хураамж нь төрийн байгууллагаас тодорхой үйлчилгээ үзүүлсний төлөө төлөх мөнгөн хөрөнгө болно.
- Хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.2.1-д “үйлдвэрлэлийн нөөцийг сорчлохгүй” байхаар заасан атал үүсмэл орд ашиглахтай холбоотой зохицуулалт давхар туссан нь агуулгын зөрчил үүсгэж байна. Иймд “үйлдвэрлэлийн нөөц”, “үүсмэл орд” гэх ойлголтуудыг тодорхойлж, холбогдох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах;
- Хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.2.4-т улсын төсвийн хөрөнгөөр хийсэн геологи, хайгуулын ажлын зардлыг гэрээнд заасны дагуу төлөөгүй нь тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болохоор заасан атал 74 дүгээр зүйлд хугацаа хэтэрсэн хоног тутам алданги тооцох, дараа жилийн ашиглалтын үйл ажиллагааны тайланг батлахгүй байхаар заасан нь агуулгын хувьд хоорондоо зөрчилтэй байгааг анхаарч залруулах;
- Хуулийн төслийн 59 дүгээр зүйлийн 59.1.5 болон 59.1.17 дахь заалтууд агуулгын хувьд давхацсан байгааг залруулах;
- Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.4 болон 6.5-д заасан төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтооход баримталсан тооцоо, судалгааг ил тод болгох.

Хуулийн шүүмж боловсруулсан:
Нээлттэй Нийгэм Форум
Монголын хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хороо



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Монгол Улс
Улаанбаатар-14240
Сүхбаатар дүүрэг
Жамъян гүний гудамж-5/1
Утас: (976) 76113207
Веб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn